

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ДОЛДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны хоёрдугаар сарын 25-ний 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 02 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 57 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|--|--|
| 1 | <p>Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх зарим Салбар зөвлөлийн даргыг томилох тухай</p> <ul style="list-style-type: none">- Батлан хамгаалах яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох- Хөдөлмөрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох- Гааль, татварын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох | <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, "Ажилд томилох тухай" Засгийн газрын 2016 оны 98 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none">1. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Бат-Очирын Батсайханыг 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар томилох2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 3-ын ".....Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга -яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал Загдсүрэнгийн Болдбаатар" гэсэн хэсгийг хүчингүй болгох3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Б.Батсайханд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн</p> |

албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, "Ажилд томилох тухай" Засгийн газрын 2016 оны 99 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн нь:

1. Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Юмдоржийн Идэрцогтыг 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар томилох

2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 11-ийн ".....Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга -яамны Төрийн нарийн бичгийн дарга Равжихын Эрдэнэбүрэн" гэсэн хэсгийг хүчингүй болгох

3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Ю.Идэрцогтод үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, "Ажилд томилох тухай" Засгийн газрын 2016 оны 107 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн :

1. Гааль, татварын ерөнхий газрын дарга Сүрэнжавын Пүрэвийг 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус агентлагийн дэргэдэх салбар зөвлөлийн даргаар томилох

2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн

| | | |
|---|---|---|
| | | хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга С.Пүрэвт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 2 | Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтаас хасах тухай | <p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" 166 дугаар тогтоолын 7,18 дугаар хавсралтууд, 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 214 дүгээр тогтоолын 2, 4, 6, 8 дугаар хавсралтуудад тус тус өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 166 дугаар тогтоолын 7, 18 дугаар хавсралтаас иргэн Мөнхбаатарын Мөнхтамир /ЗЮ94031707/, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 214 дүгээр тогтоолын 2, 6 дугаар хавсралтаас иргэн Ганбатын Ганбаяр /ЕЙ91080511/, 4, 8 дугаар хавсралтаас иргэн Баянмөнхийн Сайнжаргал /ЗЙ93111104/ нарын нэр бүхий холбогдох хэсгийг тус тус хасах</p> <p>2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> |
| 3 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын 2016 оны 02 дугаар сарын |

| | | |
|--|--|---|
| | ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай | 19-ний өдрийн ХЭГ/314 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэв. |
|--|--|---|

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА